

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 10 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017.10.23

Газрын төлбөрийн орлого:

Газрын төлбөрийн тайланг цахимаар гаргадаг болсонтой холбогдуулан мэдээллийн сантай тулгалт хийж цахимаар тайлан гаргахад шаардлагатай мэдээллийг бэлтгэж ажилласан бөгөөд 255 иргэн аж ахуйн нэгж, байгууллагын 75'258'753 сая төгрөгийн бүртгэлийг тайланд шивж оруулахад бэлтгэсэн. Үүнд:

➤ 163 иргэний 2'637'072 төгрөг

➤ 92 аж ахуйн нэгж, байгууллагын 72'621'681 төгрөгийн задаргааг нэг бүрчлэн нэр, регистрээр гаргаж тулгалт хийлээ.

Газар эзэмшигч 32 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 40 нэгж талбарын газар эзэмших, ашиглах гэрээг дүгнэсэн.

Дуудлага худалдаа:

Аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/225 дугаар захирамжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг интернетээр 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдөр "Газрын цахим бирж"-ийн www.mle.mn хаягаар 1 байршилд дуудлага худалдаа зохион байгуулагдлаа.

Сүмбэр сум 3-р багт "Амтат зоог" зоогийн газраас урагш "Дашваанжил" ХХК-ийн ШТС-ын замын эсрэг талд зарлагдсан 1900 м² газарт 4 оролцогч оролцож иргэн Ц.Мөнх-Эрдэнэ хамгийн өндөр үнийн санал буюу 11100000 /арван нэгэн сая нэг зуун мянга/ төгрөгийн үнийн санал ирүүлж ялагчаар тодорлоо.



Лот	Дүн	Дүнгийн өсөлт	Хамгийн өндөр үнэ өгсөн	Хамгийн өндөр үнэ өгсөн	Хамгийн өндөр үнэ өгсөн	Хамгийн өндөр үнэ өгсөн
1	12,500 MNT	12,500 MNT	12,500 MNT	12,500 MNT	12,500 MNT	12,500 MNT
2	12,500 MNT	12,500 MNT	12,500 MNT	12,500 MNT	12,500 MNT	12,500 MNT
3	12,500 MNT	12,500 MNT	12,500 MNT	12,500 MNT	12,500 MNT	12,500 MNT
4	12,500 MNT	12,500 MNT	12,500 MNT	12,500 MNT	12,500 MNT	12,500 MNT

Сүмбэр суманд 1 байршилд нарны цахилгаан станцын зориулалтаар 50 га газарт ТСШ-ыг зарлаад зарыг зууны мэдээ, болон цахим биржид байршуулаад байна.

Сургалт, сурталчилгаа:

Шивээговь сумын төсвийн байгууллага болон томоохон аж ахуйн нэгж байгууллагуудаар "Мэдээллийн цаг"-ийн удирдамжийг сумын Засаг даргаар батлуулан сумын төрийн байгууллага, томоохон аж ахуйн нэгж байгууллагуудаар хийж байна.

Мэдээллээр газрын харилцааны хууль тогтоомжийг сурталчлах, сумын хэмжээнд зохион байгуулагдаж буй газрын харилцаатай холбоотой үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэхээр ажиллаж байна.




Сумын төвд, 15 дугаар байрны зүүн талд байршилтай нүүрэн талын 24 ширхэг авто машины гаражуудыг нэг өнгөөр будуулан дугаартай болгон газар эзэмшигч иргэдтэй хамтран ажилласан. Цаашид сумын төвийн бүх гаражуудыг нэг өнгөөр будуулан дугаартай болгохоор ажиллаж байна.



Хаягжуулалтын тухай хууль болон гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолоор батлагдсан

журмын дагуу дагуу сүмбэр суманд хаягжуулалтын ажилд нийт 70,7 сая төгрөгөөр энэ онд хийгдсэн бөгөөд 2017 оны 10 дугаар сарын 23-нд улсын комисст хүлээлгэн өгөөд байна.



Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотгол болон сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийх "Лапланд-Эко" ХХК-тай хамтран 10 дугаар сарын 4-6-ны өдрүүдэд Сүмбэр сумын 4, 5, 6-р багийн өдөрлөг, багийн иргэдийн нийтийн хуралд Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг явцын товч мэдээлэл, бодлогын бичиг баримтын шаардлага үр дүн болон иргэдээс саналыг цаасан хэлбэрээр авч ажилласан. Өдөрлөгийн үеэр 3 багийн 180 орчим иргэд хамрагдсан.



Хот байгуулалт, оронсууц, нийтийнажахуй, чиглэлээр:

- 2017 оны 3, 4-р улиралд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгасаны дагуу Баянтал сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг байнгын ашиглалтад хүлээн авахад хамтран ажиллах саналыг ГЗБГЗГ-т албан тоот хүргүүлж, тус газраас 2017 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн дотор хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг бүрэн хүлээлгэн өгөхөөр шийдвэрлэсэн албан бичгийг ирүүлээд байна.

- 2017 оны 09 дүгээр сарын 25-нд "Шивээ-Овоо" ХК-ийн "Уурхайчдын 60 хүний суудалтай цайны газрын барилга" ын ажлын зураг болон Сүмбэр сум, 3-р баг, "Шатахуун түгээх станц ба автомашин хийгээр цэнэглэх станц"ын эскиз зургийг тус тус баталсан.

Дараах ажлуудын зургийн даалгаварыг ХОХБТХ-тэй хамтран боловсруулсан. Үүнд:

1. Аймгийн төвийн авто замын ажил

2. Найрамдал хотхоны нийтийн эзэмшлийн орон сууцнуудад барилгын дүгнэлт гаргуулах

3. Сүмбэр сумын 3-р багийн хөрсний геологийн дүгнэлтийг гаргуулах, ус зайлуулах системийн ажил

4. Дугуйн зам байгуулах ажил

5. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилтын ажил

6. Улсын чанартай авто замын дагуу гэрэлтүүлэг суурилуулах

7. Хаус хороололын ерөнхий төлөвлөгөө, нэг маягийн зураг, ГИСШ, цахилгаан хангамжийн ажил

Ажлын тоо хэмжээ, төсөв боловсруулалт:

- Мөн төлөвлөгөөнд туссан ажлаас 15 дугаар байрны гадна фасад засварын ажлыг гүйцэтгүүлэхээр төсөв тооцоог гаргаж, 8 дугаар байранд дахин хэмжилт хийж хийгдэх шаардлагатай байгаа ус хаялагын хоолойг хэсэгчлэн солих, дээвэрт хар тосон түрхлэгийг сэргээн хийх, барилгын арын тоосгон өрлөгийг бүтүүлж өрөх, 15 дугаар байрны фасад засварын ажлыг хэсэгчлэн хийх зэрэг ажлыг нэмэлтээр оруулан ажлын төсвийг гаргасан. /165,0 сая төгрөг/

- Аймгийн хэмжээн ашиглагдаж буй барилга байгууламжийн судалгаа, барилгын хувийн хэрэг хөтлөлтийн судалгаа зэргийг гаргахаар байгууллагад бүртгэлтэй байгаа барилга байгууламжийн ажлын зургаас барилгын үндсэн бүтээц, тоо хэмжээг авч судалгааны ажлыг эхлэн хийж байна.

Ажлын захиалагчийн техник хяналтыг дараах объектуудад хийж, үүрэг даалгавар, зөвлөмжийг өгч ажиллаж. Үүнд

- Баянтал сумын 152 дугаар байрны гадна "Тоглоомын талбайн тохижилт"-ийн 125,3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд үе шатны техник хяналтыг хийж ажиллаж байна. Сагсны талбайн цутгалт, хашаа явган зам, авто зогсоолын ажлууд хийгдээд байна. Ажлын гүйцэтгэл 70% хийгдээд байна.

- Сүмбэр сум, "Баянбулагийн эгнээний тохижилтын ажил"-ыг "Чингисийн отог" ХХК 79,1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгэж байна. Хяналтын явцад явган зам, хашааны ажлыг үзэж шалгаад талбайн журнал дээр тэмдэглэл хийж, албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн.

Ажлын гүйцэтгэл 70% хийгдээд байна.



- Сүмбэр сум "Усан хангамжийг сайруулах /худаг барих засварлах/ ажил"-ыг "Энхжих формат" ХХК 40,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгэж, 1

худаг засварлаж, 1 худгийг шинээр хийж, 1 худгийг шинээр барих ажлыг эхлүүлээд байна. Ажлын явц 70% хийгдээд байна.



- Сүмбэр сумын 3 дугаар багийн “Нийтийн эзэмшлийн зам талбайд сандал, хогийн сав хийх ажил”-ыг “Их зэст хөгжил” ХХК 28,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгэж байна. Ажлын явц 75% хийгдээд байна.



- Сүмбэр суманд “Айл өрхүүдийг хог хаягдал ангилан ялгах хогийн саваар хангах” ажлыг “Оч хийц” ХХК 50,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гүйцэтгэж байна. Ажлын явц 80% хийгдээд байна.



- Говьсүмбэр аймгийн “Төвийн хогийн цэгийг хашаажуулах ажил”-ыг “Суварган говь” ХХК 50,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гүйцэтгэж байна. Ажлын явц 70%-ийн гүйцэтгэлийн санхүүжилт аваад байна.



Ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох ажлын хүрээнд:

- Сүмбэр сум “Сүмбэр сум, Баянбулагийн эгнээг жишиг гудамж болгох” ажил

Улсын комисст дараах объектуудад орж ажилласан байна. Үүнд:

- Сүмбэр сумын 3 дугаар баг, “Усан спортын төв”-ийн ажил
- Сүмбэр сумын 2 дугаар баг, “2 дугаар цэцэрлэг”-ийн гадна, дотор цахилгааны засварын ажил
- Сүмбэр сум “1, 2, 3 дугаар багийн айл өрх, гудамж зам талбайн хаягжуулалт”-ын ажил
- Шивээговь сумын “3 дугаар сургуулийн дээвэр засвар”-ын ажил
- Сүмбэр сум “Өрхийн эмнэлгийн өргөтгөл, их засвар”-ын ажил

Бусад:

2017.10.09 – 2017.10.30 –ныг хүртлэх хугацаанд:

1. ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөллүүдэд сургалт зохион байгуулах
2. Аймгийн хэмжээнд ашиглагдаж буй барилга байгууламжийн судалгааг гаргаж, барилгын хувийн хэргийн бүртгэл хийх.
3. Аймгийн хэмжээнд барилгын материал үйлдвэрлэдэг аж ахуйн нэгж байгууллагуудын судалгааг нарийвчлан гаргах, ажлын байр, тоног төхөөрөмжийг газар дээр нь үзэж, зурагжуулах, ХАБЭАхуйн үзлэг шалгалтыг аймгийн МХГ-тай хамтран зохион байгуулах зэрэг ажлыг төлөвлөн ажиллах байна.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР